



**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН  
КОДЕКСИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАЙЛАН 2022 ОН**

**ДААТГАГЧ, БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА,  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ**

**Компанийн засаглал, комплайнсын хэлтэс**

# ЗОХИЦУУЛАЛТТАЙ САЛБАРЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ 2022 ОНЫ ТАЙЛАН

/ДААТГАГЧ, ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ БАНК БУС САНХҮҮГИЙН  
БАЙГУУЛЛАГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИ/

## ЦАГИЙН ТОВЧООН

### 2006 он

Монгол Улсын Их хурлаас “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

### 2007 он

“Монгол компанийн засаглалын кодекс” батлагдав.

### 2014 он

“Компанийн засаглалын кодекс”-т нэмэлт, өөрчлөлт оров.

### 2022.3.23

Санхүүгийн зохицуулах хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн баталж, нээлттэй хувьцаат компаниас гадна даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компаниуд уг кодексийг дагаж мөрдөх үүргийг хүлээв.

Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын зааврын үлгэрчилсэн загваруудыг хавсралтаар батлуулав.

### 2022.4.15

Кодекс “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэв.

### 2022.6.22

Хорооны даргын 336 дугаар тушаалаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгоход оролцогч талуудын чиг үүрэг, баримтлах зарчим, нэгдсэн зохион байгуулалт, хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх аргачлал, явцыг тодорхойлов.

### 2022.8.01

Нийт 104 зохицуулалттай этгээд /Даатгагч, ББСБ, ХОМК/-ийн компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэн тайлангийн хариугаар заавар зөвлөмж, эсхүл хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон салбарын зэрэглэл тогтоох ажлыг эхлүүлээ.

## **СУДАЛГААНЫ ТАЛААР**

Компанийн засаглалыг боловсронгуй болгох нь бизнесийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх төдийгүй хөрөнгө оруулагч, харилцагчдын хүлээлтэд тулгуурласан зах зээлийн орчин бүрдэхэд эергээр нөлөөлдөг тул улс орнуудын хувьд нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, хөгжүүлэх шаардлагатай.

Олон улсын практикт компанийн засаглалын чанар, кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зэрэглэл тогтоох аргыг ашиглаж байна.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг.

## **СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ**

- компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу тайланг үнэлэх
- компанийн засаглалын хандлага, салбарт учирч буй эрсдэлийг тодорхойлох
- үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөөлөх засаглалын үзүүлэлтийг бий болгох
- салбарын компанийн засаглалын зэрэглэл тогтоож, засаглалын тэргүүлэгч компаниудыг илрүүлэх
- компаниудад өөрийн засаглалыг харьцуулах, сайжруулахад нь зориулсан салбарын компанийн засаглалын сайн жишиг үзүүлэлтийг бий болгох
- зохицуулалтын болон компанийн дотооддоо мөрдөх дүрэм, журмыг сайжруулах
- хугацааны цуваа хэлбэрээр тоон мэдээлэл үүсгэх

## **АРГАЧЛАЛ**

Судалгаа нь даатгагч, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалт менежментийн компаниуд “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуулга бүхий үнэлгээний тайлангийн үр дүнд суурилсан.

### **Судалгааны голлох сэдэв**

1. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа
2. Дотоод эрх зүйн зохицуулалт /Бодлогын баримт бичиг, дүрэм, журам/
  - ТУЗ болон түүний дэргэдэх хороод
  - мэдээллийн ил тод байдал, тайлагнал
  - сургалтын хөтөлбөр
  - комплайнсын хяналт
  - эрсдэлийн удирдлага
  - ёс зүйн дүрэм
3. Мэдээллийн ил тод байдал /Цахим хуудасны шинэчлэл/

## Судалгаанд хэн оролцсон бэ?

Кодексийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн зохицуулалттай этгээд /Даатгагч, Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ, ХОМК/.

1. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 116 зохицуулалттай этгээд /даатгагч, ББСБ, ХОМК/-ийн компаниудад албан тоот хүргүүлснээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн нийт 114 компанийн зайны үнэлгээг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлсэн.

2. Компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.

3. Үнэлгээний дүнг үндэслэн компани тус бүрт тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлсэн ба тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлсон.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүнг тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлтэй холбоотой шийдвэр гаргах, салбарын компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж, олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.

## СУРГАЛТ

Компанийн засаглалын үнэлгээний аргачлалыг боловсруулан 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр 18 даатгагч, 36 ХОМК, 4 дүгээр сарын 13-ны өдөр 56 итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч ББСБ-ын ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарыг оролцуулсан сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.


## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

**“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээ болон түүнд үндэслэж компани бүрт тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлсэн ахиц дэвшлийн өөрчлөлт:**

*Дүрслэл 1. Цахим хуудсандаа ил болгосон мэдээлэл*




Дүрслэл 2. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшлийн үзүүлэлт




Нийт 116 зохицуулалттай этгээд /Даатгагч, ХОМК, ББСБ/-ийн компанийн кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд, 2022 оны 8 дугаар сард 55.30 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос заавар зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгсний дараах давтан үнэлгээгээр буюу 2022 оны 12 дугаар сард 71.70 хувь буюу өмнөх үнэлгээнээсээ 16.40 пунктээр өссөн үзүүлэлттэй болов.


Дүрслэл 3. Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан өөрчлөлтүүд



Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:




Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



## ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Дүрслэл 1. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшлийн үзүүлэлт



Нийт 18 даатгагчийн кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд 58.87 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгсний дараах үнэлгээ 71.00 хувь буюу өмнөхөөсөө 12.13 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2. ТУЗ-ийн бүтэц




Дүрслэл 3. ТУЗ-ийн бүрэлдэхүүн




ТУЗ нь 5-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс 1-3 нь хараат бус, 4-6 нь энгийн гишүүн байна.


Дүрслэл 4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



### Дүрслэл 5. ТУЗ-ийн үйл ажиллагаа



### Дүрслэл 6. ТУЗ-ийн бүрэлдэхүүний мэргэшил байдал



ТУЗ-ийн бүрэлдэхүүний 82 хувийг эрх зүйч, эдийн засагч, санхүүч чиглэлээр мэргэшсэн гишүүд бүрдүүлж байна.

### ТУЗ-ийн дэргэдэх хороод:

Дунджаар 70 хувь нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 1-3 гишүүнтэй.

### Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:




### Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тэргүүлэгч ТОП 5 Даатгагч:

1. "ПРАКТИКАЛ ДААТГАЛ" ХХК
2. "ГАН ЗАМ ДААТГАЛ" ХХК
3. "АГУЛА ДААТГАЛ" ХХК
4. "ТЭНГЭР ДААТГАЛ" ХХК
5. "НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ" ХХК



## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА /ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ/-ЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Дүрслэл 1. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшлийн үзүүлэлт



Итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч нийт 62 ББСБ-ын кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд, 53.10 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгсний дараах давтан үнэлгээгээр 74.20 хувь буюу өмнөхөөс 21.1 пунктээр өссөн үзүүлэлттэй болов.

Дүрслэл 2. ТУЗ-ийн бүтэц




Дүрслэл 3. ТУЗ-ийн бүрэлдэхүүн




ТУЗ нь 5-9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс 1-3 нь харгагч бус, 4-6 нь энгийн гишүүн байна.


Дүрслэл 4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Дүрслэл 5. ТУЗ-ийн үйл ажиллагаа



Дүрслэл 6. ТУЗ-ийн бүрэлдэхүүний мэргэшил байдал



ТУЗ-ийн бүрэлдэхүүний 78 хувийг эрх зүйч, эдийн засагч, санхүүч чиглэлээр мэргэшсэн гишүүд бүрдүүлж байна.

### ТУЗ-ийн дэргэдэх хороод:

Дунджаар 72 хувь нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 2 гишүүнтэй.

### Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:




### Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тэргүүлэгч ТОП 20 ББСБ:

1. “МОБИФИНАНС” ХХК
2. “ОМНИ КАПИТАЛ” ХХК
3. “БУЛЛ КАПИТАЛ” ХХК
4. “НЭТ КАПИТАЛ ФИНАНС КОРПОРАЦИ” ХХК
5. “НЬЮФОНД” ХХК
6. “ФРАНКФУРТ КАПИТАЛ” ХХК
7. “АНДУУД ФИНАНС” ХХК
8. “ЗЭЭЛ ЭМ ЭН ПЛАТФОРМ” ХХК
9. “ГЭРЭЛ ФИНАНС” ХХК
10. “ЖЭТФИНАНС” ХХК
11. “МИКРОКРЕДИТ” ХХК
12. “ИНВЕСТОС” ХХК
13. “МОНГОЛИАН МОРТГЭЙЖ ФАНД” ХХК
14. “АБТС” ХХК
15. “НАНОКАПИТАЛ” ХХК
16. “ФИНАНС ЭНД ДЕВЕЛОПМЕНТ ОФ МАЙНИНГ” ХХК
17. “ФИНРҮҮТ-ИНВЕСТМЕНТ” ХХК
18. “ЕСӨН ШИЖИР ИНВЕСТ” ХХК
19. “АШИД ГОЛОМТ” ХХК
20. “БИЧИЛ ГЛОБУС ФИНАНС” ХХК

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН КОМПАНИУДЫН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Дүрслэл 1. Кодексийн хэрэгжилтийн тайлангийн ахиц дэвшлийн үзүүлэлт




Нийт 36 Хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын кодексийн хэрэгжилтийг үнэлэхэд 54.01 хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгсний дараах үнэлгээ 69.97 хувь буюу өмнөхөөсөө 15.96 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Дүрслэл 2. ТУЗ-ийн бүтэц




Дүрслэл 3. ТУЗ-ийн бүрэлдэхүүн




ТУЗ нь 1-3 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнээс 1 нь хараат бус, 2 нь энгийн гишүүн байна.


Дүрслэл 4. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



### Дүрслэл 5. ТУЗ-ийн үйл ажиллагаа



### Дүрслэл 6. ТУЗ-ийн бүрэлдэхүүний мэргэшил байдал



ТУЗ-ийн бүрэлдэхүүний 82 хувийг эрх зүйч, эдийн засагч, санхүүч, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн гишүүд бүрдүүлж байна.

### ТУЗ-ийн дэргэдэх хороод:

Дунджаар 80 хувь нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр дунджаар 1-3 гишүүнтэй.

### Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



### Компанийн засаглалын хэрэгжилтийн үнэлгээний тэргүүлэгч ТОП 10 ХОМК:

1. “БИ БИ ЭС ЭЙ ҮЦК” ХХК
2. “УЛААНБААТАР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
3. “СОД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
4. “АШИД АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
5. “АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
6. “ҮҮРЭГ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
7. “СТЕПП МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
8. “ИНВЕСКОР АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК
9. “ЭМ АЙ ДИ ЭЙ ЭС ҮЦК” ХХК
10. “ТИ ДИ БИ АССЕТ МЕНЕЖМЕНТ ҮЦК” ХХК

